

МОНГОЛ, ХЯТАДЫН ХООРОНД ХИЛ ТОГТООХ БОЛСОН ШААРДЛАГА

THE RATIONALE FOR A SINO-MONGOLIAN BORDER



МОНГОЛ
ХИЛ СУДЛАЛ

Е.Берикжан*

Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлгийн штабын дарга, докторант, дэд хурандаа
Lt. Col. Berikjan E, Head of Headquarters General Hospital for State Special Servants, Ph.D
Candidate in Border Studies, University of Internal Affairs

Х.Асхар

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй
байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн профессор, доктор, хурандаа
Col. Askhar Kh, Ph.D, Professor, Department Border Checkpoint Security and Inspection, Border
Protection Service School, University of Internal Affairs

*Хариуцлагатай зохиогч: e.berikjan@gmail.com,

Хураангуй: Аливаа улс өөрийн бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын асуудлаа хөрш зэргэлдээ улстай байгуулсан олон улсын гэрээг үндэслэн улсын хилээ тогтоож, зааглаж, олон улсад хүлээн зөвшөөрүүлэх замаар шийдвэрлүүлэх зүй тогтол олон улсын практикт нэгэнтээ тогтсон байна. Хөрш улсын нутаг дэвсгэрийн хил хязгаараас зааглаж, тухайн улсууд хоорондоо олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг улсын хил” гэж үздэг. Энэхүү өгүүлэлээр дамжуулан өөрийн судалгааны ажлын нэг хэсэг болох Монгол Улсын тэр тундаа Монгол-Хятадын хилийн хэсгийн хилийг тогтоох болсон шаардлага, ямар хүчин зүйлс нөлөөлж байсан, тогтоосон хилээ хэрхэн хамтран шалгаж байсан гэсэн асуудлын хүрээнд түүхэн талаасаа ямар ач холбогдолтой байсан, ямар үр дагаврыг авчирсан зэрэг асуудлыг нарийн нягтлан судалж, тухайн үеийн удирдлагууд хөрш зэргэлдээ улстай хэрхэн гадаад харилцаагаа бэхжүүлж байсан талаар хүргэхийг зорисон болно. Улсын хилийг тогтооход үүсэж байсан урьдач нөхцөл байдал, хүндрэлүүд зэрэг олон асуудал гарч байсан нь түүхийн эх сурвалжууд болох ялангуяа архивын түүхэн баримтууд, салбарын эрдэмтэн, судлаачдын бүтээлүүдэд тэмдэглэгдэн үлджээ. Судалгааны ажлыг түүхэн архивын эх сурвалжийн материалыг цуглуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх судалгааны арга зүйд тулгуурлан бичиж, судлаачийн зүгээс гаргасан дүгнэлт, саналыг дэвшүүлсэн нь өмнө нь нийтлэгдэж байсан өгүүлэлээс онцлог болох юм. Аливаа түүхэн цаг хугацааны асуудал нь өөрөө өнгөрсөн үеийн туршлага, гашуун сургамж болдог зүй тогтол оршдог тул судалгааны ажлын практик ач холбогдол оршиж байна.

Abstract: The establishment, demarcation, and international recognition of borders are fundamental to a state's sovereignty and independence. These processes are guided by international agreements with neighboring states and are critical components of state-building. This study focuses on the historical and geopolitical process of defining Mongolian state borders, particularly the Sino-Mongolian border, examining the key factors that necessitated their establishment, the influences that shaped the process, and the joint verification efforts undertaken with neighboring states. Through a historical lens, the article explores how Mongolian leaders of the time navigated foreign relations to secure and consolidate these borders, emphasizing the significance and consequences of these efforts. The study draws on archival documents, historical sources, and scholarly research to trace the challenges and preconditions encountered in border establishment. Employing a methodology of source collection, analysis, and synthesis, the research presents findings and offers insights into the broader implications of border demarcation for Mongolia's sovereignty.

This research underscores the enduring relevance of historical events as reservoirs of experience and lessons, offering practical insights for addressing contemporary issues of state sovereignty and territorial integrity.

Түлхүүр үг: Хил тогтоох, тэмдэглэх, хамтран шалгах, дипломат харилцаа.

Keyword: Demarcation and delimitation borders, peer review, diplomatic relations.

Үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна” (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 1992), Монгол Улс нь Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 1992) гэж заасан нь НҮБ-ын дүрмийн нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх, улсын хил халдашгүй дархан байх, олон улсын үүргээ шударгаар биелүүлэх гэсэн тулгуур зарчимд үндэслэгдсэн. Эдгээр зарчим нь Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны олон улсын харилцааг зохицуулах эрх зүйн үндэс, тусгаар тогтнолын баталгаа болох агуулгыг илэрхийлж байна.

Сүүлийн үед олон улсад болж өрнөж буй улс хоорондын зэвсэгт мөргөлдөөн, газар нутгийн маргаантай асуудал зэрэг нь хил

судлалын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж буй эрдэмтэн, судлаачдын анхаарлын төвд байх зайлшгүй хэрэгцээ, шаардлага байгааг дараах бодит жишээнүүдээс харж болно.

Жишээ 1: Бүс нутгийн хэмжээнд буюу манай улсад шууд хамааралтай зүүн хойд азийн аюулгүй байдалтай холбоотой асуудлыг дурдахад:

Тус бүс нутагт:

- Орос-Японы /Куриллын арлын/
- Япон-Өмнөд Солонгос /Такэшима/

Докодо арлын/

- Хятад-Японы /Сенкаку арлын/
- Хятад-Өмнөд Солонгос

- Хятад-Японы хоорондын гээд газар

нутгийн болон усан хилийн маргаантай асуудлууд нэлээд бий. Энэ бүс нутагт улс орнууд газар нутгийн маргааны улмаас хоорондын харилцаанд зөрчил, маргааныг байнга дагуулсаар ирж байна. Үүнийг хүснэгт 1-ээр харуулвал дараах байдлаар харагдаж байна.

Газар нутгийн маргаан	ОХУ	Япон	БНХАУ	БНСУ	БНАСАУ
Курилын зарим арлууд	+	+			
Сенкаку арал		+	+		
Даманскийн арал	+		+		
Нэг үндэстэний газар нутгийн хуваагдал				+	+
Далай, тэнгисийн эдийн засгийн чөлөөт бүсийн хил хязгаарын маргаан	+	+	+	+	+
Тайвань тусгаар улс, аль эсхүл БНХАУ-ын нэг гэж үзэх ээдрээтэй асуудал			+		

Хүснэгт 1. Зүүн хойд азийн бүс нутагт оршин буй газар нутгийн маргаантай асуудал Эх сурвалж: Судлаачийн гаргасан харьцуулалт

Дээрх хүснэгтээс харахад энэ бүс нутагт дэлхийд тэргүүлэгч эдгээр улсууд одоог хүртэл хилийн асуудлаа бүрэн шийдэж, хилээ албан ёсоор баталгаажуулаагүй байна.

Жишээ 2: Сүүлийн 30 жил Орос Украины хооронд уламжлалт бус арга хэрэгслээр явагдсан саарал бүс дэх ажиллагаа нь улам даамжирч, зөрчил, сөргөлдөөн нь дээд цэгтээ хүрснээр, 2022 оны хоёрдугаар сарын 24-нөөс уламжлалт дайны хэлбэрт шилжээд жил гаруй хугацаа өнгөрөв. ОХУ нь Украинд өргөн фронтоор довтолсноор хоёр тал албан ёсны дипломат

харилцаагаа тасалж, үлэмж хэмжээний хохирол амсаад байна. ЗХУ задран унасны дараа Украин нь тусгаар тогтнолоо баталгаажуулах, ОХУ-аас зайгаа барих, Европын холбоо, НАТО-той ойртох гадаад бодлого баримталж эхэлсэн нь энэ дайны улс төрийн шалтгаан болсон төдийгүй өрнө-дорно, ОХУ-Европын хоорондох Украины газарзүйн онцгой байршил, эдийн засаг, хөдөө аж ахуй, дэд бүтэц, байгалийн нөөц баялгийн төлөөх их гүрнүүдийн өрсөлдөөн олон жил үргэлжилж, ОХУ-Украиныг уламжлалт дайнд, ОХУ-АНУ



МОНГОЛ УЛСЫН Дотоод Асуудлын Их Сургууль



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ

тэргүүтэй барууны орнуудыг саарал дайнд хүргэсэн гэж олон улс судлаачид үздэг.

Ялангуяа 2014 онд Украинд гарсан төрийн эргэлтийн үеэр Оросын тодорхойгүй зэвсэгт бүлэглэл Крымын хойгийг эзэлж, улмаар тус улс өөртөө нэгтгэсэн. Үүний дараа Оросын талыг баримтлагч салан тусгаарлагчид Украины Донбасст нэгэн зэрэг байлдаж эхэлсэн явдал нь олон жил үргэлжилсэн саарал бүсийн ажиллагааг хурцатгасан нь өнөөдрийн цэргийн хүч хэрэгслээр бүрэн утгаараа явагдаж буй уламжлалт дайны суурийг тавьж өгөв. Энэ мэтчилэн олон улсад өрнөж буй зэвсэгт мөргөлдөөний үндсэн суурь нөхцөл нь тухайн улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолтой холбоотой асуудал шууд хөндөгдөх хор уршигтай байдаг тул Монгол Улс хилээ тогтооход үүсэж байсан урьдач нөхцөл, суурь шалтгаан, шаардлагыг судалж, ирээдүй болсон хойч үедээ бичиж үлдээх нь эрдэмтэн, судлаачдын бидний үүрэг хэмээн үзсэн болно.

Үндсэн хэсэг

XX зууны 60-аад оны эхээр Монгол, Хятадын хилийн гэрээг байгуулсан (Баатархүү, 2023) үйл явц тодорхой хугацаанд үргэлжилсэн бөгөөд тухайн үеийн олон улсын нөхцөл байдал төдийлөн тогтвортой бус байсан гэж эрдэмтэн судлаачид үздэг. Хоёр улс хилээ тогтоох, хилийн гэрээг байгуулах дээр дурдсан хугацаанд дараах олон улсын цэрэг-улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, зарим хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзэж болохоор байна. Үүнийг дэлгэрүүлэн авч үзсэн болно. Үүнд:

Нэгдүгээрт: Дэлхийн II дайн Зөвлөлт Холбоот Улс болон түүний холбоотны ялалтаар төгсөж, Дорнын улс түмнийг Японы дарлалаас Чөлөөлөх дайнд Бүгд Найрамдах Монгол Ард Улс (цаашид БНМАУ гэх)-ын хувьсгалт цэрэг, Зөвлөлтийн улаан армитай мөр зэрэгцэн хамтарч Өвөр Монгол, Зүүн хойд Хятадын ард түмнийг чөлөөлсөн нь БНМАУ, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид БНХАУ гэх)-тай найрсаг харилцаа тогтооход чухал хүчин зүйл болжээ. Манай өмнөд хөрш 1949 оны 10 дугаар сарын 01-ний өдөр тусгаар тогтнолоо

тунхаглан зарлаж, дэлхийн олон улсуудад БНХАУ-тай дипломат харилцаа тогтоох тухай тунхаг бичгийг илгээсэн байдаг. Үүний хариуд БНМАУ-ын Засгийн газар 1949 оны 10 дугаар сарын 06-нд Бээжинд явуулсан илгээлтдээ: “БНМАУ-ын Засгийн газар Хятадын ард түмэнтэй найрсаг харилцаа тогтоохыг цаг ямагт эрмэлзэж байдаг учир монголын бүх ард түмний хүсэл зоригийг илэрхийлэн БНМАУ ба БНХАУ-ын хооронд дипломат төлөөлөгч нараа харилцан солилцохоор тогтов” (Хайсандай, 2012) гэж мэдэгджээ.

Мөн Хятадын Ардын засгийн газраас 1950 оны 2 дугаар сард Зөвлөлт Холбоот Улсын Засгийн газартай солилцсон нот бичигт БНМАУ-ын тусгаар тогтнол нь 1945 оны санал хураалт ба БНХАУ-аас түүнтэй дипломат харилцаа тогтоосны дүнд бүрэн хангагдсан гэж баталжээ. Улмаар 1952 онд БНМАУ, БНХАУ-ын хооронд эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай, 1960 онд Нөхөрлөл, хамтын ажиллагааны тухай гэрээнүүдийг байгуулсан төдийгүй тэдгээр хэлэлцээрт заасан харилцан бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, эрх тэгш байдлыг хүндэтгэх, талуудын эрх ашгийг хангасан байх, дотоод хэрэгт үл оролцох, сайн хөршийн харилцааг тогтоох зэрэг зарчмуудыг тусгасан байна.

Хоёрдугаарт: БНМАУ ба ЗСБНХУ-ын хооронд байгуулсан нөхөрлөл ба харилцан туслалцах, хамтран ажиллах тухай хэлэлцээрийн дагуу Зөвлөлтийн цэргийн ангиудыг 1950-аад оны эхээр Монголын өмнөд хилээс эргүүлэн татсан нь БНМАУ, БНХАУ-ын улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаа сайжирах нөхцөл бүрэлдсэн.

Гуравдугаарт: Дэлхийн II дайны дараа Нэгдсэн Үндэсний Байгууллага (цаашид НҮБ гэх) байгуулагдсан боловч дэлхийн нөлөө бүхий улс орнууд капиталист, социалист системд хуваагдан сөргөлдөх болсон.

Дөрөвдүгээрт: Улс орны бүрэн эрхт байдлаас түүний нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байх, хид хязгаар нь халдашгүй дархан байх зарчим урган гарч ирдэг. Энэхүү зарчим нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн зарчим болон батлагдсан. НҮБ-ын гишүүн улс бүр олон

улсын харилцаанд аливаа улс гүрний нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг хүчээр заналхийлэх буюу хүч хэрэглэхийг цээрлэхийг заасан байдаг. Тиймээс ч Монгол Улс олон жилийн уйгагүй тэмцлийнхээ үр дүнд 1961 оны 10 дугаар сарын 27-нд НҮБ-д бүрэн эрхт гишүүнээр элссэн нь Монгол Улс тусгаар тогтнолоо олон улсын тавцанд бүрэн баталгаажуулсан юм. БНМАУ НҮБ-д элссэн боловч хөрш зэргэлдээ орших БНХАУ-тай улсын хилийн шугамаа тогтоон тэмдэглэж чадаагүй байлаа.

Тавдугаарт: Монгол, Хятадын хооронд найрамдалт харилцаа тогтоосон нь 2 орны хилийн цагийн байдалд нөлөөлж, улсын хилийн зөрчил будилаан буурч, тайван байдалд шилжжээ. Үүний үр дүнд 1951 оноос улсын хилийг хамгаалж байсан Хилийн цэргийн анги, салбаруудыг татан буулгаж, орон тоог цомхотгон цөөлсөн төдийгүй манай өмнөд хөрш ч мөн адил улсын хилээ цэргийн хүч хэрэгслээр хамгаалахаас татгалзаж билээ. 1953 он гэхэд Монгол, Хятадын хилийн дагуу нийт 10 пункт үлдсэн бөгөөд тус бүрдээ дунджаар “...450 км хилийн хэсгийг офицер 1, ахлагч 3, хугацаат албаны түрүүч байлдагч 10-12, зэвсэглэлийн хувьд гар буу 3, винтов 14, уналгын морь, тэмээ 36-тай...” (Цэдэн-Иш, 2011) хариуцан хамгаалах болжээ.

Улсын хилийг цэрэг, зэвсгийн хүчээр хамгаалах явдлыг таслан зогсоосон тул хоёр улсын Засгийн газар хил дээр болсон аливаа асуудлыг онцгойлон анхаарч хилийн зөрчлийг газар дээр нь богино хугацаанд шийдвэрлэж байхыг 2 тал чухалчилж байв. Тухайлбал, 1954 оны зун дорнод аймгийн нутагт хур бороо их хэмжээгээр орсон учир 600 гаруй адуу салхи уруудан хил давж Хятадын нутагт оржээ. Манай талаас эдгээр адууны талаар БНХАУ-ын хилийн төлөөлөгчдөд мэдэгдсэний үр дүнд тус 600 гаруй адууг 1954 оны 11 дүгээр сард Баянхошуу, Өвдөгийн чиглэлээр хүлээн авчээ.

Түүнчлэн Монгол-Хятадын хил орчмын ард иргэд цаг агаарын хүндэрсэн нөхцөлд бие биеийнхээ нутгийн аль тааламжтай хэсэгт хоёр улсын Засгийн газрын тохиролцсоны дагуу нутаглуулж байв. 1956-1958 онд Дорноговь аймгийн

хилийн сумдын нутаг дэвсгэрт ган болсон учир тус аймгийн Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдын 193 өрх айл, 30 орчим мянган толгой малтайгаа Өмнөговь аймгийн Ханбогд сумын 150 өрх айлын 200 гаруй хүн 25000 гаруй толгой малтайгаа Өвөр Монгол Баяннуур аймгийн Дунд хойд холбоот хошууны нутаг Цонж, Улаанхүрээнд 1958 оны 01-09 дүгээр сар хүртэл нутаглаж байв. Мөн БНХАУ-ын Хөлөнбуйр аймгийн зүүн шинэ барга ба баруун шинэ барга хошуудаас Дорнод аймгийн Халхгол, Чойбалсан сумын нутагт 1956-1957 оны өвөл, хаврын цаг агаарын хүндэрсэн нөхцөлд 500 мянга гаруй малыг нутаглуулжээ.

Дээрх түүхэн баримтуудыг дүгнэж үзвэл Монгол Улс, БНХАУ-ын хил залгаа орон нутгийн засаг захиргаа, тэдгээрийн удирдлага, хил хамгаалалтын салбар, нэгжүүд болон хил орчмын ард иргэд хоёр улсын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийг чанд сахин мөрдөж, улсын хилийг зөрчилгүй байлгах бүхий л арга хэмжээг хамтран хэрэгжүүлж байсны илрэл гэж үзэж болох юм.

БНМАУ-ын Засгийн газар өмнө зүгийн түүхэн хилийн шугамын байршлыг тодруулах талаар анхаарал тавьж, зарим арга хэмжээ авч байжээ. Тухайлбал, 1948 онд Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Ламжаваар толгойлуулсан тусгай комисс томилон өмнө зүгийн хилийн түүхэн овоо тэмдгийн байршлыг шалгуулсан байх бөгөөд тус комисс, 1951 он хүртэл ажиллаж өмнө зүгийн хилийн бүх түүхэн овоо тэмдгийн байршлыг судалж, тодорхойлолт үйлджээ.

Монгол, Хятадын хилийг тодорхой болгох үүднээс БНМАУ-ын Засгийн газраас 1958 онд БНХАУ-ын Засгийн газарт хоёр улсын хилийг тодотгож тогтоох, хилийн хэлэлцээ явуулах талаар санал тавьсан байна. Манай саналыг Хятадын тал авч үзээд 1958 оны 03 дугаар сарын 28-нд ирүүлсэн нот бичигтээ Хятадын Засгийн газар нь хилийн хэлэлцээ явуулахыг зөвшөөрч байна. Монгол, Хятадын хооронд тодорхой хил үгүйлэгдэж байна. Монголын тусгаар тогтнолыг зөвшилцөхдөө одоогийн хилээр гэсэн нь дараа хил тогтоох явдалд зарчмын үндэс болно гэсэн хариу өгчээ. Манай Засгийн газар, Хятадын Засгийн газрын нот



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ХЭЛЭЛЦЭЭНД
ОДООГИЙН ХИЛЭЭ БАРИМТАЛНА

бичгийг авч үзээд Б.Цэдэн-Иш, Элчин сайд О.Хосбаяр, хошууч генерал Д.Батаа нарын боловсруулсан хилийн хэлэлцээнд “Одоогийн хилээ баримтална” (ХХЕГ, 2004) гэсэн саналын дагуу 1921 оны Ардын хувьсгалаас хойш хамгаалж ирсэн одоогийн хилийн шугамыг газрын зурагт тэмдэглэж, 1958 оны 07 дугаар сарын 21-ний өдөр нот дагалдуулан БНХАУ-ын Засгийн газарт хүргүүлсэн байна.

Ийнхүү БНХАУ-тай хилийн хэлэлцээ явагдах болсон учир МАХН-ын төв Хорооны Улс Төрийн Товчоо 1960 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор БНМАУ, БНХАУ-ын хоорондын улсын хилийн шугамыг судлах, хэлэлцээрт бэлтгэх экспертийн бүлгийг томилжээ. Экспертийн бүлгийг Гадаад явдлын яамны сайд Д.Моломжамц удирдаж, ажлын хэсгийг нь мөн яамны коллегийн гишүүн Б.Цэдэн-Иш ахалж байжээ.

Экспертийн бүлэг 1960-1961 онд Монгол Улсын өмнө зүгийн хилийн талаар маш нарийн судалгаа хийжээ. Улсын төв архив, Гадаад явдлын яам, Нийгмийг аюулаас хамгаалах яам, Батлан хамгаалах яамны архивууд, Шинжлэх ухааны академи, Улсын төв номын сан зэрэг олон газарт хадгалагдаж байсан хилийн холбогдолтой түүхэн баримт бичиг, аймаг хошуудын нутгийн цэс зургууд, бусад холбогдох материалыг цуглуулан судалж, халхын дөрвөн аймаг, Дарьгангын тусгай хошууны хил дээр байгаа 191 овоо тэмдгийг хэн, хэдэн онд ямар хэлэлцээрээр босгож хил тэмдэглэснийг тогтоожээ. Түүнчлэн өмнө зүгийн хилийн дагуу 2500 гаруй км явж судалгаа хийн, 174 овооны байршлыг газар дээр нь тодруулж, 50 гаруй хуудас материал бэлтгэсэн нь манай талаас хилийн хэлэлцээнд орох судалгааны ажлыг үндсэндээ хангажээ.

Харин Хятадын талаас улсын хилийн дагуу олон тооны групп, хэсгүүдийг гаргаж газрын зураг үйлдэх, газар орон хэмжих, хилийн овоо тэмдгүүд дээр тоо, дугаар тавих, шинээр багана мод босгох, хилийн овоонуудын хоорондох зайг тодорхойлох ажилд шуурхайлан оржээ. Түүнчлэн хилийн дагуух газар орны ойн баялаг, ашигт малтмалын нөөцийг тогтоох, илрүүлэхийн тулд “..... хилийн бүх шугамын

дагуу болон хэсэгчлэн онгоц нисгэнэ. Тэгэхдээ танай нутгийн гүнд 10-30 км орно...” (Даваадорж, 2018) гэдгээ 1957-1961 онд 10 гаруй удаа дипломат шугамаар мэдэгдэж, БНМАУ-ын Засгийн газраас зөвшөөрөл авч байжээ.

БНХАУ-ын Засгийн газраас 1962 оны 03 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн нотдоо Хятадын тал хилийн хэлэлцээ явуулахад татгалзах зүйлгүй бэлэн гэдгээ илэрхийлсэн байдаг. Манай талаас албаны зарим ажилтнууд улсын хилийг эндүүрэн зөрчиж байсан явдлыг зогсоох арга хэмжээ авч байсан. Ойрын хугацаанд хилийн хэлэлцээ явуулахыг халуун дотноор уриалж байна гэсэн утга бүхий албан ёсны нот бичгийг явуулсан байжээ.

Үүний хариуд манай Засгийн газар БНХАУ-ын Засгийн газрын шийдвэрийг хүлээн аваад Сайд нарын Зөвлөлийн 1962 оны 377 дугаар тогтоол гаргаж, Хилийн хэлэлцээнд оролцох бүрэлдэхүүнийг Гадаад явдлын яам 3, Нийгмийг аюулаас хамгаалах яам 3, Ардын цэргийн хэрэг эрхлэх яам 1, Шинжлэх ухааны академи 2, Барилгын зургийн институт 1, өмнө зүгийн хилийн 8 аймгаас тус бүр 1 төлөөлөгчдийг томилсон байна.

Хилийн хэлэлцээ эхлэхийн өмнө 2 тал зарчмын асуудлаар санал солилцож тохиролцсон байна. Үүнд: “Хилийн шугамыг тогтоохдоо өмнө гарч байсан газар нутгийн маргааныг авч хэлэлцэхгүй, Монголын одоогийн хилийн шугамыг үндэслэн тогтооно. Дайны үед улсын хилээ хамгаалж байсан хилийн застав, харуул, манааны байрууд халдашгүй дархан байх ёстой” гэсэн саналыг манай талаас тавьж, Хятадын талаар зөвшөөрүүлсэн байна. Үүний үр дүнд Монгол Улсын 8 аймгийн 39 сум, БНХАУ-ын 2 өөртөө засах орон, 1 муж, 26 сум, хот, хошууг хамарсан нутаг дэвсгэрийг хоёр тал хэлэлцээрийн ширээний ард суун шийдвэрлүүлэх ажлыг эхлүүлсэн байна.

Дүгнэлт

Улсын хил олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдөж тогтоогдсоноор улс орнууд өөрийн эзэмшлийн газар нутагтай болж, тусгаар тогтнол, бүрэн эрхээ баталгаажуулдаг. Энэ бүхнээс үзэхэд Монгол-Хятадын хил 1962 онд албан ёсоор

тогтоон тэмдэглэгдэж, олон улсад баталгаажсан нь хоёр улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдалд шийдвэрлэх нөлөөг үзүүлсэн гэж дүгнэж байна.

Аливаа улсын хилийн харилцаа өөрийн гэсэн онцлогтой, эерэг, сөрөг шинж чанарыг агуулах нь зүй ёсны үзэгдэл бөгөөд тухайн цаг үеийнхээ нөхцөл байдлаас шалтгаалж, ямагт хэвийн тогтвортой, сайнаар үргэлжлэн хөгждөггүй, өрнөлт бууралт нь алиныг даван туулсаар ирсэн байдаг зүй тогтолыг манай улс тойроод гарсангүй дайраад гарсан нь дээрх үндсэн хэсэгт өгүүлсэн түүхэн мэдээлэл, баримтуудаар нотлогдож байна. Тэгэхээр үүний нэгэн адил БНМАУ, БНХАУ-ын хилийн харилцаа, хамтын ажиллагаа нь дэлхий дахины цэрэг, улс төр, нийгэм-эдийн засгийн зөрчилт байдлаас шалтгаалж, янз бүрийн саад бэрхшээлийн дунд үргэлжлэн хөгжсөөр өнөөг хүрсэнийг энэхүү өгүүлээр дамжуулан хүргэх зорилгоо хангасан гэж дүгнэж болохоор байна.

Санал

“Монгол, Хятадын хооронд хил тогтоох болсон шаардлага” сэдвээр бичиж буй энэхүү түүхэн судалгааны хүрээнд гарсан үр дүн, дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Эдгээр санал нь цаашид судлаачид түүхийн асуудлыг судлах, судалгааны ажлыг явуулахад хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Үүнд:

1.Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Сургалтын хөтөлбөрт Хил хамгаалалтын түүхийн

хичээлээр энэхүү түүхийн асуудлыг оруулдаг байх. Ингэснээр тус сургуулийг төгссөн офицерүүд манай улсын хил хамгаалалтын түүхийг мэдэхээс гадна хилийн тулгамдсан асуудалыг төр засгаас яаж шийдвэрлэж ирсэн уламжлал, сургамжийг мэдэх болно.

2.Энэ сэдвээр хилийн анги, салбарын ахлагч, харуулын дарга бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусган оруулж байх.

Ашигласан материал

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (1992). *Монгол Улсын Үндсэн хууль*. Retrieved from <https://legalinfo.mn>

Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ). (2004). БНМАУ-ын газар зүйн байршил, нутаг дэвсгэр. *БНМАУ-ын газар зүйн байршил, нутаг дэвсгэр* (х. 178). Улаанбаатар: Хил хамгаалах ерөнхий газрын хэвлэх цех.

Баатархүү, К. (2023). The historical significance of the Mongolian-Chinese border agreement. *Indiana Journal of Humanities and Social Sciences*, 1, 1–5.

Даваадорж, Б. (2018). Эх орны төлөө. *Цэрэг улс төрийн түүхийн судалгаа* (х. 56). Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Хайсандай, Л. (2012). Монголын улс төрийн гадаад харилцааны түүх (1911–1999). *Монголын улс төрийн гадаад харилцааны түүх (1911–1999)* (х. 209). Улаанбаатар.

Цэдэн-Иш, Б. (2011). Монгол Улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс. *Монгол Улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс* (х. 25). Улаанбаатар: Мөнхийн үсэг.



МОНГОЛЫН
УЛСЫН
ДЭВСГЭР
ХАМГААЛАХ
ЕРӨНХИЙ
ГАЗАР